# Матай 10:37–39

Хос хосоор юм уу жижиг бүлгээрээ, оногдсон шүлгүүдээ хамтдаа уншиж, асуултуудын хариултыг ярилц.

Матай 10:37–38-ыг уншин, бид Түүний шавь нарын хувьд хийхэд бэлэн байх ёстой золиослолууд юу болох талаар Аврагчийн хэлснийг олж мэд. Эдгээр шүлгэн дэх "миний хувьд зохистой" гэдэг нь Их Эзэний зөв зохистой төлөөлөгчид байж мөн Түүний адислалуудыг авахад тэнцэхүйц байх гэдэг утгатай юм.

- Есүс Христийн шавь нарын хувьд Түүнийг бусдаас илүүгээр, бүр өөрийн гэр бүлийн гишүүдээс илүү хайрлах нь яагаад чухал гэж та нар бодож байна вэ?

38-р шүлэгт дурдагдсан загалмай нь Есүс Христийн үүрсэн мөн Эцэгийнхээ хүслийг гүйцэлдүүлэхээр хадагдсан тэр бодит загалмайг далдуур хэлж байгаа юм. Үүнчлэн, Есүс Христ Өөрийн дагалдагчдыг үүний адил "[тэднийг] загалмайгаа үүрч, [Түүнийг] дагахад" дууджээ (Матай 16:24).

Иосеф Смитийн Орчуулга, Матай 16:26-г (Матай 16:24, зүүлт тайлбар *д*) уншаад мөн загалмайгаа үүрч, Есүс Христийг дагана гэдэг нь бидний хувьд ямар утгатайг олж мэд.

Матай 10:39-ийг уншаад, золиослолын талаар Есүс Христийн заасан зарчмуудыг олж мэд. Иосеф Смитийн Орчуулга нь энэ шүлгийн эхлэлийг "Өөрийн амьдралыг аврахыг эрэлхийлдэг тэр нь . . ." (39-р шүлэг, зүүлт тайлбар *а*-г үзнэ үү) гэж эхлүүлснээр тодорхой болгодог. Энэ сэдэвт "өөрийн амьдралыг аврах" гэдэг нь Бурханд болон Түүний хүүхдүүдэд үйлчлэхийг эрэлхийлэхийн оронд хувиа бодон амьдрах гэсэн утгатай.

- Өөрсдийн таалалд болон хувиа бодсон хүсэлдээ анхаарал төвлөрүүлдэг хүмүүс амьдралаа ямар ямар замаар яваандаа "алдана" гэж та нар бодож байна вэ?

Өөрсдийн уншсан дээр үндэслэн, дараах зарчмыг гүйцээ.

**Хэрэв бид өөрсдийн амьдралыг аврахаар эрэлхийлбэл** _____.

Аврагчийн төлөө амьдралаа алддаг хүмүүст Түүний өгсөн амлалтыг 39-р шүлэг дээрээс тэмдэглэх талаар бодно уу. Түүний төлөө амьдралаа алдах гэдэг нь Түүний төлөө үхэхэд бэлэн байхаас илүү өргөн утгатай юм. Энэ нь Түүнд болон эргэн тойронд маань байгаа хүмүүст үйлчлэхээр өдөр бүр өөрсдийгөө зориулахад бэлэн байна гэсэн үг юм.

- Бид өөрсдийгөө Түүний төлөө алдах үедээ өөрсдийн амьдралыг олох болно гэдэг нь ямар утгатай гэж та нар бодож байна вэ?

Өөрсдийн уншсан дээр үндэслэн, дараах зарчмыг гүйцээ.

**Бид Есүс Христийн төлөө өөрсдийн амьдралыг алдвал,** _____.



© 2016 BY INTELLECTUAL RESERVE, INC. БҮХ ЭРХ ХАМГААЛАГДСАН.

Ерөнхийлөгч Томас С.Монсоны дараах мэдэгдлийг уншаад, дагалдах асуултуудын хариултыг ярилц.

"Бид бусдад үйлчлэхэд өөрсдийгөө зориулахгүй бол бидний амьдралын зорилго өчүүхэн юм гэдгийг Аврагч бидэнд захиж хэлсэн гэдэгт би итгэдэг. Зөвхөн өөрийнхөө төлөө амьдардаг хүмүүс эцэстээ хатаж хорчийдог, зүйрлэвээс амиа алддаг бол бусдад үйлчлэхэд өөрсдийгөө зориулдаг хүмүүс өсөж дэвжин, амиа авардаг билээ" ("Өнөөдөр би хэн нэгний төлөө юу хийв?" *Ensign* эсвэл *2009 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 96).

- Та нар Есүс Христийн төлөө амьдралаа умартахаар сонгосон хэнийг мэддэг вэ? Энэ шийдвэр нь тэр хүнд хэрхэн нөлөөлсөн бэ?



© 2016 BY INTELLECTUAL RESERVE, INC. БҮХ ЭРХ ХАМГААЛАГДСАН.